

“ИЛТ НОМЫН САНГААС ЭХТЭЙ ЭРГЭЛЗЭЭГ ТАСДАГЧ ЭРДЭНИЙН ТОДОРХОЙ ЗУЛ” ЗОХИОЛЫН БҮТЭЦ АГУУЛГА, ҮЗЭЛ САНААГ ШИНЖЛЭХ НЬ

Дэд профессор Г.Эрдэнэбаяр, доктор(Ph.D)
С.Дэмбэрэл, докторант
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үг: Буддха, абхидхарма, дүрс, сэтгэл, хуран бус үйлдэгч, сэтгэлээс гарсан, төгөлдөр бус хуран үйлдэгч, мөнх бус, цувиралт, би үгүй, амгалан

Товч утга:

Тус өгүүлэлд буддын гүн ухааны аймаг болох абхидхармын гол эх судруудын үүсэл хөгжил, хувьсалын явцад буй болсон Энэтхэгийн сэтгэгч Васубандхугийн “Абхидхармакоша” зохиолын сэдэв, бүтэц агуулга, үзэл санаа, буддын гүн ухааны бүтээлүүд дотор эдлэх байр суурь, онцлог байдал, ач холбогдлыг тодруулах болно.

“Абхидхармакоша” нь буддын танин мэдэхүй, метафизик, космологи, хүний амьдралын зовлон жаргалын асуудал, ёс зүй, хүний сэтгэлийн олон хэв шинжүүд, гэгээрэлд хүрэх зам мөр, бясалгал, билиг оюун зэрэг өргөн сэдвийг хөндсөн зохиол юм.

Тиймээс “Абхидхармакоша” зохиол нь Энэтхэг, Төвөд, Монгол, Буриад, Тува, Халимаг, Өвөр Монголын буддын гүн ухааны дацангийн сургалтад чухал гарын авлага болдог. Монголчууд “Абхидхармакоша” шастирт олон тайлбар хийж ирсний нэг нь Эрэн хамба Лувсанцэрэнгийн (1873-1934) “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” хэмээх зохиол болой.

Лувсанцэрэн хамбын бүтээл нь буддын гүн ухааны нэр томъёо, ойлголтуудыг тодотгох үүднээс буддын гүн ухааны

мэтгэлцээний хэлбэрт оруулан тайлбарлах хэлбэрээр бичигдсэнээрээ онцлог юм.

Абхидхармакоша шастирын үүсэл хөгжил, бүтэц агуулга, үзэл санаа

Шашин судлалын үүднээс авч үзвэл шашин болгон шашны онолын болон гүн ухааны гол эх сурвалжтай байдаг ба тэдгээр нь түүхийн явцад хувирч, хөгжиж ирсэн байдаг. Буддха (НТӨ VI зуунд) төгс гэгээрч “Хутагтын дөрвөн үнэний” сургаалаа айлдан 40 орчим жил номлолоо дэлгэрүүлж, НТӨ 483 онд(Sharma, 1987, p.70) таалал төгссөний дараа түүний шавь Кашьяпа (Kasyapa) удирдан хуврагийн анхдугаар чуулганыг Ражгирт(Rajagrha) хуралдуулж буддын гол сургаал номлолыг винайн сав аймаг, судрын сав аймаг, абхидхармын сав аймаг гэсэн гурван сав аймагт эмхэтгэн бичиг үсэгт буулган үлдээжээ(Olson, 2011, p.223) . Тэдгээрээс абхидхарма буюу гүн ухааны сав аймаг нь: 1. “Билиг дор орохуй”, 2. “Сайтар үйлдэгч”, 3. “Мэдэхүйн чуулган”, 4. “Номын цогц”, 5. “Нэрийдэхүйн шастир”, 6. “Амьтны зүйл”, 7. “Язгуурын чуулган” гэсэн долоон¹ (Ролбийдорж, 2021, хууд. 104) эх судраас бүрддэг байна. МЭ V зуунд Энэтхэгийн их бандид Васубандху дээрх долоон эх судрын гол утгыг нь товч, тодорхой, системтэй эмхэтгэн “Абхидхармакоша” (Илт номын сан) хэмээх

1 1. Ye shes la 'ajug pa, 2. rab tu byed pa, 3. rnam shes kyi tshogs, 4. chos kyi phung po, 5. gdags pa 'i bstan bcos, 6. 'agro ba 'I rnam grangs, 7. khams kyi tshog te bdun yin,

зохиол бичжээ. “Абхидхармакоша”-ын бүтээлийн онцлогийг дурдвал:

1. Бурхан багшийн сургаалыг эмхэтгэн гүн ухааны гол нөлөө бүхий эх сурвалж болсноор буддизмд хагарал, үл ойлголцлолыг зогсоожээ.
2. Буддхагийн айлдсан судруудад байдаг гүн ухааны гол ойлголтуудыг хооронд нь зөрчилдүүлэлгүйгээр уялдаа холбоотой тайлбарлаж чадсан
3. Судар болон абхидхармын олон тооны эх сурвалжуудын гол утгыг нэгтгэн хураангуйлж зааж, сургах, түгээхэд амар хялбар болгосон
4. Буддхагийн сургаалд буй шийдэх, хариулах, тайлбарлахад хүндрэлтэй гүн ухааны ойлголтуудыг цэгцэлж, нэгдсэн, цогц, логик уялдаа холбоотой, тодорхой эмх цэгцтэй дэс дараалалд оруулж уг сургаал дахь ойлгомжгүй бүрхэг асуудлыг тодорхой болгож, Энэтхэгийн оюун санаа, шашны хөгжилд гарч байсан өөрчлөлтүүдийг тусгасан өгсөн
5. Абхидхармын гол эх сурвалж болон хожимын буддын сэтгэгчдийн гүн ухааны үзэл санаа, чиг хандлагыг нэгтгэн тусгасан буй
6. Буддын гүн ухааны гол ойлголт, чиг хандлагууд, маргаантай асуудлуудыг нэгтгэн тодорхойлж тайлбарласан
7. Буддизмын гүн ухааны сургуулиудын зөрөөтэй олон янзын ойлголт, тайлбаруудыг өөрсдийнх нь байр сууринаас шийдэж, ойлголцол бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн
8. Эх сурвалжийг бүтээхдээ нэгтгэх, харьцуулах, ангилах, жишээ татаж, үлгэрлэж, зураглан тайлбарлах, нарийвчлан задлах, хураангуйлах,

дүгнэх аргуудыг өргөн хэрэглэсэн байдаг.

Иймд Буддын шашны их, бага хөлгөний урсгалыг дагагчид Абхидхармакошад чухал ач холбогдол өгч дээдийн номын гол утга, гүн ухаанд суралцаж ирсэн байна.

Васубандхугийн (V зуун) “Абхидхармакоша” зохиол нь 1. Үзэгдэгч дүрсийн суурь, 2. Чухал сэтгэлийн суурь, 3. Хуран бус үйлдэгчийн суурь, 4. Дагалдагч сэтгэлээс гарахын суурь, 5. Төгөлдөр бус хуран үйлдэгчийн суурь² гэсэн сэдвийн хүрээнд сав, шим ертөнц, хүмүүн бодьгал өөрийгөө танин мэдэх, гэгээрэлд хүрэхэд хэрэгтэй гол ойлголтуудыг тайлбарласан байдаг.

Мөн “Абхидхармакоша”-д буддын шашны тулгуур номлол болох дөрвөн үнэний анхдугаар үнэн зовлонгийн үнэний мөн чанар, түүний учир шалтгаан, нөхцлийн талаар өгүүлсэн зовлонгийн шалтгааны үнэн, зовлонг хаахын үнэн буюу гуравдугаар үнэн, зовлонгоос ангижран гэгээрэлд хүрэх арга замыг заасан мөрийн дөрөвдүгээр үнэний талаар тодорхой өгүүлнэ. Анхдугаар үнэн болох зовлонгийн үнэнд зовлон бүгдийн үндэс суурь таван цогц бөгөөд таван цогцыг минийх хэмээн барих сэтгэлээс шунал тачаал, уур хилэн, мунхаг гэх мэт нисванисын гурван хор үүсэх ба зовлон бүхэн бүтэхийг номложээ.

Васубандху (V зуун) тус бүтээлдээ дүрс, сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэхүй хэмээх таван цогцод³ () шүтсэнээс хүмүүст баясах, сэтгэл ханах тэргүүтэн түр зуурын амгалан тааламжтай сэтгэл төрөх ч, тэрхүү сэтгэлийг үүсгэгч таван цогцоос гарах аливаа зүйлс агшин төдийд ч тогтвортой үл орших ба үргэлж хувьсан өөрчлөгдөх мөнх бус чанартай тул

2 1. *Snang ba gsugs kyi gzhi*, 2. *gtso bo sems kyi gzhi*, 3. *'akhor sems byung gi gzhi*, 4. *ldan pa ma yin pa 'I 'adu byed gzhi*

3 *slo dpon sha' kya'i dge slong dbyig gnyen*. “*chos mngon pa'i mdzod kyi tshig le'ur byas pa*” *CIHTS, Sarnath, Varanasi (U.P) India, 1995, p 149*

аливаа “минийх” гэж барисан таван цогц өөрчлөгдөн хувьсах үед хүмүүс зовлонг эдэлнэ. Аливаа эд зүйлст шунах хүсэл нь зовлон бүгдийн үндэс болох ба түүнийг тэвчсэнээр зовлонгийн үргэлжлэх шалтгаан нөхцөл тасарч, зовлонгоос гэтлэн гэгээрэлд хүрч болохыг заасан байдаг.

Абхидхармын суурь ойлголт дээр тулгуурлан сав шимийн ертөнцийн аливаа эд юмсын мөнх бус, эзэн би үгүй мөн чанар, тэдгээрийн хурах, эвдрэх, үйлийн үрийн нөхцөл шалтгаан, зовлонгоос ангижиран амгаланд хүрэх гэсэн буддын гүн ухааны дөрвөн үндсэн тулгуур үзэл болох:

1. Хуран үйлдсэн бүхэн мөнх бус
2. Цувиралт сэлт бүхэн зовлон
3. Алив эд юмс\дхарма бүхэн эзэн би үгүй
4. Гаслангаас нөхцөж гэтлэн амгаланд хүрэх⁴

гэх мэтийг танин мэдэхэд буддын сургаалд суралцагчдад дөхөм болдог ажээ.

Абхидхармакошыг судалж олж авсан мэдлэг нь оюун ухааныг буддын шашны гүн ухааны гол номлол болсон мөнх бус, би-үгүй, хоосон чанарыг онож мэдэхэд хандуулдаг.

Монголд буддын шашин дэлгэрсэн цагаас “Абхидхармакоша” шастир нь монголчуудын түүх бичлэг, ертөнцийг үзэх үзэл, төр, шашны харилцаа, гэгээрлийн зам мөрд чухал нөлөө үзүүлсэн байдаг.

Тиймээс эрт дээр үеэс Монголын сүм хийдийн сургалтанд “Абхидхармакоша” чухал байр суурь эзэлж, түүнийг тайлбарласан олон бүтээлийг монгол эрдэмтэн мэргэд туурвиж иржээ.

Монгол мэргэдээс их хүрээний цорж З.Агваанбалдан, Эрэн хамба

Лувсанцэрэн, Эрдэнэ зуу хийдийн ширээт лам Гончигжалцан, Өлгийн лама Лувсанчойндон, Үйзан вангийн хошууны Ишнамжил, Мөрөнгийн хүрээний Цэрэнжав аграмба, Брагри Ёнзин Дамцигдорж, Дашдо гүнгийн хошууны Данзинчойнзод нарын арав гаруй лам(Буамбаа, 2005, р. 44-69) “Абхидхармакоша” зохиолын тайлбарыг төвөд хэлээр бичиж туурвиж байжээ.

Тэдний дотроос Үржин гүний хүрээ буюу одоогийн Булган аймгийн Баян-Агт сумын харъяат Эрэн хамба Лувсанцэрэн (1873-1934) “Абхидхармакоша” бүтээлийн бүх бүлгийн гүн ухааны бэрх ойлголт, түүний утга, агуулгын эргэлзээг тодруулан тайлбарласан “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” хэмээх өвөрмөц зохиолыг туурвисан байна. Түүний зохиолыг Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын харъяат Гандантэгчэнлин хийдийн лам Нямсүрэнгийн Гончигдорж (1907-1990) хадгалж байгаад буддын судлаач Р.Бямбаад (2013) өвлүүлэн өгчээ. Тус судар нь 41 х 10 см хэмжээтэй цаасан дээр хар бэхээр найман мөрөөр төвөд үсгээр 882 нүүр, 441 хуудастай найман бүлэгтэй судар хэлбэрээр бичигдсэнийг Р.Бямбаа (2013) дахин хэвлүүлж судалгааны эргэлтэд оруулжээ.

Эрэн хамбыг “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” тайлбар зохиолыг туурвихад Дарва бандид Лувсан Агваан Чойжор Дондүв Балсанбо(1870-1927) дурдатган сануулж⁵ бичүүлсэн бололтой. Түүний тайлбар зохиол нь академич Д.Цэрэнсодномын (1997) “шашны гүн ухаан, дотоод үзэл, зан үйл тэргүүтний талаар туурвисан аливаа зохиол бүтээлийн утга чанарыг яруу тодорхой ойлгомжтой болгохын

4 1. 'adu byed thams cad mi rtag cin, 2.zag bcas tham cad sdug bsngal ba, 3. Chos rnamst ston zhin bdag med pa, 4. Mya ngan las 'adas pa zhi ba'o

5 Эрэн хамба Лувсанцэрэн, Chos mngon mdzod las brtsams pa'i dogs gcod rin chen gsal ba'i sgron me zhes bya ba la // gnas brgyad po'i skabs bzhugs so // Ilt nomyn sangaas tuurvikhyn sejiigi taslagch ikh erdenii todorkhoi zul khemeekh. Naim-dugaar орны үйе оршивои. төгсгөлийн үг, х880

үүднээс тайлбар зохиолын төрөл зүйл буй болжээ”(Д.Цэрэнсодном, 1997, хууд. 274) гэсэн тодорхойлолтод дурдсанаар Абхидхармакошын утга чанарыг ойлгомжтой болгохын тулд бичигджээ. Буддын гүн ухаан түүхэн дэлгэрэлтийнхээ явцад өөр хэл соёл, сэтгэлгээтэй Азийн ард түмний дунд түгэхдээ гүн ухааны гол эх судар, шастирын үг, утга, бэрх ойлголтыг тайлбарласан “тайлбар зохиолын” төрөл зүйлийг бий болгосон байдаг. Төвөдийн эрдэмтэн Дунгар Лувсанпэрэнлэй тайлбар зохиолын төрөл зүйлийг зургаан төрлийн тайлбар, гурван зүйлийн тайлбар хэмээн хоёр янзаар авч үзсэн⁶ тухай судлаач Г. Мягмарсүрэн(2021) судалгааны бүтээлдээ төвөд хэлнээс орчуулан (Г.Мягмарсүрэн, 2021, хууд. 116-117) дараах эрэмбээр дурджээ.

“Зургаан тайлбар” нь:

1. Үгийн тайлбар (tib: tshig ‘grel)
2. Утгын тайлбар (tib: don ‘grel)
3. Ялгах тайлбар (tib: ‘byed ‘grel)
4. Агуу их тайлбар (tib: rgya cher ‘grel)
5. Бэрхийн тайлбар (tib: dka’ ‘grel)
6. Үлгэр тайлбар (tib: sgrung ‘grel)

“Гурван зүйл тайлбар” нь:

1. Үгийн тайлбар (tib: tshig ‘grel)
2. Утгын тайлбар (tib: don ‘grel)
3. Сүвэгч буюу бэрхийн тайлбар (tib: mchan ‘grel, dka’ ‘grel) гэх зэргээр ялгаж ангилжээ.

Энэ өгүүлэлд дурдсан Эрэн хамба Лувсанцэрэнгийн “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” хэмээх бүтээлийг Абхидхармакоша шастирыг өргөн цар хүрээтэй тайлбарласан утгын тайлбар, бэрхийн тайлбар, агуу их

тайлбарын төрөлд ч хамааруулж болох онцлогтой юм.

Тэрээр “Абхидхармакоша” зохиолын сэлэв, агуулга, ойлголтын эргэлзээг тайлахын тулд Энэтхэгийн бандида нарын зургаан тайлбар зохиол⁷ (Лувсанцэрэн, хууд. 789), Төвөдийн мэргэдийн арав гаруй тайлбарыг⁸ (Лувсанцэрэн, хууд. 880) харьцуулан судалж ноттой буулгажээ.

Эрэн хамба Лувсанцэрэн болон түүний бүтээл нь хэдийгээр XIX зууны эхэнд үед зохиогдож 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн шуурганд хэлмэгдэж явсан ч түүний зохиол бүтээл нь өнөөдөр ч сэдэв, агуулга, ач холбогдолоо алдаагүй байна. Тэрээр өөрийн бүтээлдээ “Шашны наран баруун уулын үзүүрт жаргаад, шашин даруй энэ цаг дор үл үзэгдэж болоод, шашны номлолыг найруулсан гайхамшигт сайн энэ номлолыг, шашны гал дахин сэргэхийн ойрын шалтгаан болгомуй (Р.Бямбаа, 2013, хууд. 879)” хэмээсэн нь 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн үед шашин номын үйлд шамдан суралцах нь улс төрийн үзэл сурталын сүүдэрт хаалттай болж байсан ч лам хуврагууд бурханы шашны энэхүү гол номлол сургаалд суралцах үйлийг үргэлжүүлэх аваас шашин дахин сэргэхэд тустай хэмээн үзэж тус бүтээлийг туурвисан бололтой.

Зохиогч бээр цааш нь “үзэл бодлын цөвүүн машин дэлгэрэх энэ цагт, муу үзэлт шашны дайсны ёрын дуун ихэд цуурайтсан ч, үнэхээр ариун үзлийг үл булаан чадах үед, энэ мэт үзэл шинжлэл нь үнэхээр гайхамшигтай”(Р.Бямбаа, 2013, хууд. 879) хэмээн буддын сургаал номлолыг магтсан үзэл санааг илэрхийлжээ.

6 *Dung dkar blo bzang ‘phrin las, dung dkar tshig mdzod cen mo, krung go’I bod rig pa dpe skrun khang, China, 2002, p 635*

7 1. ‘grel bshad gang spel, 2. rgyal sras ma, 3. blo brtan ‘grel bshad, 4. slob dpon zhi ba lha’I ‘grel bshad, 5. phyogs glang gi gnad don, 6. kha che ‘dus bzang gi mdo dang mthun pa,

8 *Mchim ti’ka, thar lam gsal byed, chos mngon rin chen shin rta, ser rje btsun pa rang nyid kyi mdzod, kun mkhyen mdzod las, pan chen mdzod, drung chen mdzod sogs kyi bzhung bsrangs te, dpal ldan chos rje’I mdzod, gun thang blo gros kyi mdzod, bstan sgron chos mdzad pa’I mdzod,*

Лувсанцэрэн хамба “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” зохиолын бүтэц, бүлэг тус бүрийн агуулга

Лувсанцэрэн хамба нь “Абхидхармакоша” шастирын нийт 8 бүлгийн бүтэц агуулгыг баримтлан өөрийн тайлбар бүтээлээ туурвисан байдаг./Энэхүү зохиолын үйлийн үрийг үзүүлсэн дөрөвдүгээр бүлэг нь гээгджээ/ Васубхандхугийн Абхидхармакоша зава шастир нь шүлэглэсэн хэлбэрээр бичигдсэн байдаг бол түүнийг тайлбарласан Лувсанцэрэн хамбын бүтээл нь буддын гүн ухааны нэр томъёо, ойлголтуудыг тодотгох үүднээс буддын гүн ухааны мэтгэлцээний хэлбэрт оруулан тайлбарлах хэлбэрээр бичигдсэнээр онцлог юм.

Лувсанцэрэн хамба “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” зохиолоо туурвихдаа “Абхидхармакоша”-ын бүлэг орныг баримтлан найман хэсэгт хуваан, уламжлалт төвөд сударын боть, бүлгийг дугаарлан ангилдаг ёсоор төвөд хэлний цагаан толгойн ka, kha, ga, nga, ca, cha, ja, nya гэсэн эхний найман үсгийн дарааллаар ангилж, бүлэг орон тус бүрийг 98-131 хуудсанд багтаан бичжээ.

Нэгдүгээр бүлгийг язгуурыг үзүүлсэн хэмээнэ. /Төвөдөөр: gnas dang po khams bstan pa/ Энэхүү бүлгийн эхэнд зохиогчийн өөрийн мөргөл залбирал болон зохиолоо ямар нэг саад бэрхшээл хүндрэлгүйгээр бүтээж дуусгахын тулд “Гэтэлгэгч лам, зоригдол үгүй, их нийгүүлсэхүй төгөлдөр нугуудад бишрэн мөргөмүй, их энэрэхүй бээр даган барьж соёрх”(Лувсанцэрэн, хууд. 1) хэмээн залбирал одуулж, бүтээлээ

саадгүй дуусгахыг даатгажээ. Зохиогч өөрийн тайлбар бүтээлийн зорилгоо лам багшдаа даатган “Номтой барилдахын язгуур үндэс лам, бурханд, Дээдийн номын авралыг бодтой өөр бусад олохын тул, Илт номын сэжгийг таслах төдийн үйлдэхийн тулд, Номтой зохилдон сэтгэлээр бишрэн мөргөмүй” хэмээн мөргөн залбирчээ.

Зохиогч удаагаар нь зохиолоо бичих болсон шалтгаанаа “дээдийн номын аврал утгыг өөрөө хийгээд бусад олохын тул болой” хэмээн тодотгон өгүүлжээ.

Түүний дараагаар цувиралт, цувиралтгүйн юмс⁹ болон хуран үүдсэн ба эс хуран үүдсэн юмс¹⁰ үзэгдлийн мөн чанар, тодорхойлолтыг өгүүлнэ. Мөн дүрсийн цогцын мөн чанар, тодорхойлолт, түүний ялгааг үзүүлнэ. Язгуурын дөрвөн үндсэн махбодь¹¹ болох шороо, ус, гал, хийн мөн чанар тэдгээрийн үүрэг, үйл ажиллагааг заана. Дүрсийн цогцоос бусад дөрвөн цогцын ялгаа, цогц, язгуур орны махбод, төрөн түгэхүйн юмсын хоорондын ялгал, тэдгээрийн бие биендээ хураагдах ёсыг тодорхой харуулсан байдаг. Түүнээс гадна номын 80 мянган цогцыг тоолох ёсон болон язгуурын орны 22 эрхтэнийг¹² ялгаж тоочин үзүүлдэг.

Хоёрдугаар бүлгийг эрхтнийг үзүүлсэн орон гэж нэрийднэ /Төвөдөөр: gnas gnyis pa dbang po bstan pa/ Энэхүү бүлэг нь эрхтэний талаар өгүүлсэн байдаг. Түүнд эхлээд 22 эрхтэнийг тус тусад нь ангилан ялган тоочих ёс, тэдгээрийн үйл ажиллагаа, үүргийг заана. Сэрлийн таван эрхтэний мөн чанар, хир үгүй гурван эрхтэний тодорхойлолтыг тус тус үзүүлдэг. Мөн сэтгэл болон сэтгэлээс гарсан үр дагаварын ялгал, 14 төгөлдөр бус хуран үйлдсэн

⁹ zag bcas, zag med gyi chos

¹⁰ ‘du byed, ‘du ma byed gyi chos

¹¹ ‘byung ba bzhi

¹² Dbang po nyer gnyis

юмсын ялгаа¹³, нэр, үг, үсэг гурвын ялгаа зааг, 6 үндэс, уг шалтгаан¹⁴ ба 5 үр дагавар¹⁵, 4 нөхцөл шалтгааны ялгал¹⁶ болон түүний дараагаар 12 сэтгэлийн тийн ялгал сэлтийг үзүүлдэг болой.

Гуравдугаар бүлгийг ертөнц дахиныг үзүүлсэн орон хэмээнэ. /Төвөдөөр: gnas gsum pa 'jig rten bstan pa/ ертөнцийн зүй тогтолыг үзүүлсэн байдаг. Савын ертөнц болон шимийн ертөнцийг тодорхойлон үзүүлээд түүнд багтах хүслийн, дүрстийн, дүрст үгүйн орны ялгал болоод тодорхойлолт, 7 орон¹⁷ болон төрөх 4 орны ялгал¹⁸, савын ертөнцийн орны үүсэж тогтсон ёс, шимийн ертөнцийн үүсэл, уул, нуур, 4 тив¹⁹ үүсэж бий болсон ёс, дээд доод төрлөөс доод муу заяаны төрөл болох 18 тамын²⁰ тухай, нар, сар, од эрхэсийн хоорондын уялдаа холбоо, тэдгээрийн хөдөлгөөн, амьтаны биеийн хэмжээ болон насны хэмжээ, 4 галба эриний²¹ хэмжээг тоолох ёсон ба галба юүлэх буюу эвдрэх ёсыг тус тус энэхүү бүлэгт үзүүлнэ.

Дөрөвдүгээр бүлгийг үйл үзүүлсэн орон гэнэ /Төвөдөөр: gnas bzhi pa las bstan pa/ Үйлийн үр түүний учир шалтгаан буюу кармаг үзүүлнэ. **Лувсанцэрэн хамбын “Илт номын сангаас эхтэй эргэлзээг**

тасдагч эрдэнийн тодорхой зул” зохиолоос энэхүү бүлэг нь ороо бусгаа цагийн эрхээр гээгдэж алга болжээ. Абхидхармакоша зава шастирын энэхүү бүлэгт үйлийн үрийн мөн чанар, түүний шинж байдал, ялгалуудыг үзүүлнэ. Дараагаар нь үйлийн үр тийн ухагч хийгээд тийн үл ухагчийн алинд хамаарах, эдгээрээс гарах долоон буяны тодорхойлолт, үйлийн ялгаа, ангид арилагчийн сахил санваар болон даяаны санваарыг тоолох ёс, тэдгээр нь алинд төгөлдөр болох ёс, түүнийг олох ёс болон өгөх ёс, бага хөлгөний шарваагийн ёсны аврал одуулахын ёсыг тодорхой өгүүлэх ба Судраас гарсан 15 үйлийн үрийн ялгалыг заасан байдаг.

Тавдугаар бүлгийг нарийн өрвөтгөлийг |дэлгэрэнгүйг үзүүлсэн орон гэж нэрийднэ /Төвөдөөр: gnas lnga pa phra rgyas bstan pa/ Энэхүү бүлэг нь гаслан зовлонт сэтгэлийн шинж чанар, төлөв байдал, хэв шинжийн ялгааг тодорхойлно. Зовлонт сэтгэл үгүйгээр үйлийн үр эс хурах бөгөөд үйлийн үргүйгээр сав болон шимийн ертөнц боловсорч чадахгүй ба тиймээс үйлийн үрийн үндэс болсон гаслант сэтгэлийн ялгааг энэхүү бүлэгт номлосон байдаг. Гаслант сэтгэлийг дотор нь зургаа

13 Төвөд-хятад хэлний их толь, 1-р дэвтэрт 14 төгөлдөр бус хуран үйлдсэн юмсыг

1. олох, 2. үл олох, 3. хувь тэгш, 4. хуран мэдэхүй үгүй, 5. хуран мэдэхүйн тэгш орох, 6. хаахын тэгш орох, 7. амь, 8. төрөх, 9. өтлөх, 10. орших, 11. эвдрэх, 12. нэр, 13. үг, 14. үсэг хэмээн тодорхойлжээ.

14 Rgyu drug, Зургаан уг шалтгаан нь: 1. үйлдэгчийн шалтгаан, 2. нэг дор хамт гарахын шалтгаан, 3. хувь тэгшийн шалтгаан, 4. адил төгөлдөрийн шалтгаан, 5. бүхэнд одогчийн шалтгаан, 6. тийн боловсролын шалтгаан тэргүүтэн болно.

15 'bras bu, Таван үрийг дотор нь: 1. шалтгаан зохилдохын үр, 2. өөрийн үр, 3. төрөлхтөн үйлдэхийн үр, 4. тийн боловсролын үр, 5. хагацахын үр гэж ангилна.

16 Rkyen bzhi, Дөрвөн нөхцөл нь: Шалтгааны нөхцөл, 2. даруй түргэн нөхцөл, 3. зорилгот тусгай нөхцөл, 4. өөрийн нөхцөл сэлт болно.

17 Srid pa bdup, 1. Тэнгэр, 2. хүн, 3. адгуус, 4. бирд, 5. там, 6. завсарын орон, 7. үйлийн орон тэргүүтэн долоон орон болно.

18 Skye gnas bzhis, 1. Өндөгнөөс төрөх, 2. дулаан чийгнээс төрөх, 3. умайнаас төрөх, 4. хувилан төрөх

19 Gling bzhi, 1. Зүүн зүгт үлэмж биетний тив, 2. урд зүгт замбуу тив, 3. баруун зүгт үхэр адгуулагч, 4. хойд зүгт зохист бус дуутны тив тус тус оршино.

20 Tsha dmyal brgyad, grang dmyal brgyad, nye 'khor ba 'I dmyal ba brgyad, Халуун найман там, хүйтэн найман там, орчин тойрны там, хэсэг бусаг там нийт 18 болно

21 Skal ba bzhis, Завсарын галба, их галба, хоосон галба, шимийн галба

болон арав, 98 хэсэг болгон ангилсан байдаг. Тэрслүү 4 үзлийг²² тайлбарлах ёс, омог дээрэнгүйг 7, 9, 3н хэсэг болгон тус тусад нь ангилах ёс, зовлонт сэтгэлийг ялгах ёс болон тэрээр алинд тогтох, 3 цагийн ялгаа, ном сонсох үед гарах зургаан гэм²³, таван түйтгэр²⁴, зовлонт сэтгэл үүсэхийн учир шалтгаан, тэдгээрийн эрэмбэ дарааг тодорхой заан үзүүлсэн байна.

Зургаадугаар бүлгийг мөр хийгээд бодгалийг үзүүлсэн хэмээн нэрлэдэг / Төвөдөөр: gnas drug pa lam dang gang zag bstan pa/ Уг бүлэгт гэгээрлийн зам мөр болон тэрхүү мөрөөр одогч бодгаль хүний тухай өгүүлнэ. Дээр өгүүлсэн зовлонт сэтгэлийг тэвчих мөрд орохын чухалыг өгүүлэн мөрийн мөн чанар, дөрвөн үнэний ялгал хийгээд үүсгэхийн зэрэг, хуран үйлдсэн бvхэн зовлонд бүтэхийн ёс, хоёр үнэний мөн чанар болон тэдгээрийн тодорхойлолт, амирлангуй суурь орны бясалгал болон үлэмж үзэл хоёрыг бясалгах ёсон, чуулганы мөр, барилдлагын мөр, үзэх мөр гурвыг бясалгах ёс хийгээд тэдгээрийн ялгаа, үзэх мөрийн арван зургаан агшин болон түүнд

орших дөрвөн үе, үр боловсролын дөрвөн орны ялгал, номын хүрдийг эргүүлсэн ёс, сүсэг төрөх ёс, сурах хийгээд үл сурах номын өвөрмөц ялгаа сэлтийг үзүүлдэг болой.

Долдугаар бүлгийг бэлгэ билгийг үзүүлсэн орон хэмээнэ /Төвөдөөр: gnas bdun pa ye shes bstan pa/ Энэхүү бүлэг нь арван мэдэл²⁵ хийгээд түүний мөн чанар, арван мэдэл хэмээн тоочиж ангилахын ёсны учир шалтгаан, хутагтын арван газрын шүтээн мэдэл тэдгээрийг баттай буй болгох ёсон, мэдлийн зорилго, түүнийг баттай төгс олох ёс, билэг оюуныг мэдсэнээр хураахын эрдэмд ер бусын дээдийн ном хийгээд нийтийн эгэл ертөнцийн ном хэмээн хоёр хуваагаад ер бусын дээдийн номд бурхан бээр номыг үл холих эндүүрэх 18-н дээд чанарын тодорхойлолт²⁶, ерийн үед гаслан үгүй болон хүсээд мэдэх, анагаах дөрөв, тэдгээрийг олох ёс, түүний удаагаар 6 илт мэдэл²⁷, 3 ухаан²⁸, 3 рид хувилгааны²⁹ тодорхойлолт сэлтийг өгүүлдэг.

Наймдугаар бүлгийг тэгш орохуйг үзүүлсэн хэмээнэ. /Төвөдөөр: gnas brgyad

22 *Lta ba bzhi*, Бохырыг ариунд барих үзэл, эзэн би үгүйг эсрэгээр барих үзэл, зовлонг амгаланд барих үзэл, мөнх бус зүйлийг мөнхөд барих үзэл тус тус орно.

23 *Dri ma drug*, Омгорхог сэтгэл, үл хүндлэх, утгыг анхаарч үл авах, сэтгэл алгасрах, сэтгэл мунхрах, сэтгэл гунихрах

24 *Sgrib ba lnga*, Догирох гэмших, хорлох сэтгэл, будангуйрах сэтгэл, дур тачаал, эргэлзэн тээнэгэлзэх

25 *Shes pa bcu*, Бурханы гэгээрлийн газрын арван мэдэл нь: 1.Номын мэдэл, 2.даган мэдэл, 3.зовлонг мэдэх, 4.зовлонгийн шалтгаан бүхэн гарахыг мэдэх, 5.зовлонг хаахыг мэдэх, 6.зам мөрийг мэдэх, 7.барагдахыг мэдэх, 8.үл төрөхийг мэдэх, 9.янагуух үнэнийг мэдэх, 10. бусдын сэтгэлийг мэдэх сэлт болно.

26 *Sangs rgyas kyi chos ma 'dres pa bco brgyad*, 1.Эндүүрлээс ангижирсан, 2.хатуу ширүүн үгээр үл өгүүлэх, 3.мартах явдлаас чөлөөтэй, 4. хэзээд сэтгэлээ нэг зүгт хандуулах, 5.Элдэв хуран мэдлийг үл үүсгэх, 6.тус тус үл шинжлэхийн санаа амирлахаас ангижирсан, 7.зорилгоосоо үл шантрах, 8.хичээл шамдалаа үл орхих, 9.дурдал сэтгэлийг үл алдах, 10.бясалгалд баттай орших, 11.билиг оюуныг үл алдах, 12. тийн гэтлэхийг үл алдах, 13. тийн гэтлэхийн билиг оюуныг үл дордуулах, 14. биеийн бүх үйл ажиллагааг билиг оюунаар зохицуулах, 15. хэл ярианы бүх үйл ажиллагааг билиг оюунаар удирдах, 16.сэтгэлийн бүх үйлийг билиг оюунаар зохицуулах, 17.өнгөрсөн цагийн үйл явдалд үл тачаах, үл тотгорлогдох билиг оюун, мэдэлтэй, 18. одоо цагийн үйл явдалд үл тачаах, үл тотгорлогдох мэдэл гэх мэт арван найман дээд чанартай болно.

27 *Mngon shes drug*, Рид хувилгааны илт мэдэл, тэнгэрийн мэлмийн илт мэдэл, тэнгэрийн сонорын илт мэдэл, бусдын сэтгэлийг мэдэх илт мэдэл, урдын явдлыг хойно санах илт мэдэл, цуврилт юмс барагдахыг мэдэх илт мэдэл тэргүүтэн зургаа болно.

28 *Rig pa gsum*, Төгсгөлийн мөрийн үед үүсэх гурван илт мэдэл нь: 1.Урьдын орон буюу урдын хязгаарыг мэдэх мэдэл, 2. үхэх хийгээд үхлийн дараагийн төрлийг мэдэх, 3. цуврилт юмс барагдахыг мэдэх мэдэл гэх мэт гурав болно.

29 *Cho 'phrul gsum*, Бурхан багшийн шавь нартаа үйлсийг зохион үзүүлсэн бие, хэл, сэтгэлийн рид хувилгаан

pa snyoms 'jug bstan pa/ Энэхүү бүлэг нь даяан буюу бясалгалд орох ёсыг өгүүлсэн байдаг. Энэ бүлэгт номлох гол сэдэв нь бясалгалын дөрвөн үе³⁰ болон дүрс үгүй дөрвөн орны³¹ тухай бөгөөд эхлээд даяаны мөн чанар, тодорхойлолт, ялгал, даяаны салбар хэлбэрийн үе шат, түүнийг олох ёс, урьдах бясалгалын аль үе шатны дараа түүнийг шүтээн суурь болгон дараагийн ямар бясалгал болон дүрс үгүйн орны үе шат магадтай эхлэх ёс, нэг даяанаас нөгөө даяанд шилжих буюу даяанаас дүрс үгүйн орны даяанд шилжих хооронд хийх завсарын бэлтгэл үеийн бясалгалын тодорхойлолт, дияаныг дотор нь орон хийгээд зам мөр, мөрөөс мохох хэмээн ялгаж ангилах ёс, түүний дараагаар бясалгалаар хурсан эрдэмд цаглашгүй дөрөв³² хийгээд, тийн гэтлэгч найм, сүрээр дарагч найм, барагдагч аравын ялгал буюу тэдгээрийг олох ёс, түүний дараагаар буддын шашин энэ ертөнцөд хэдий хугацаагаар оршин тогтнох хэмжээ тэргүүтнийг үзүүлсэн болой.

Дүгнэлт:

Буддын гүн ухааны гол эх сурвалж болсон Васубандхугийн “Абхидхармакоша” шастирын утга, үзэл санаа, ойлголтын эргэлзээг тайлж, ойлгомжтой тайлбарласан зохиол нь Эрэн хамба Лувсанцэрэнгийн “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” хэмээх бүтээл юм.

Тэрээр тус тайлбарыг бичихдээ Энэтхэг, Төвөдийн мэргэдийн Абхидхармакошын хорь орчим тайлбар зохиолыг уншиж магадлахаас гадна Дармакиртийн “Шалгадаг ухааны тийн тайлбар”, Чандракиртийн “Төв үзэлд орохуй”, Жанжаа хутагт Ролбийдоржийн “Тогтсон таалал”, Пагва лам Лодойжанцангийн “Мэдэгдэхүүн машинд тодруулсан шастир” Богд Зонхова Лувсандагвын “Билиг барамидын гол шастир Илт онохуйн чимгийн тайлбар сайтар номлолын алтан эрхи”, “Төв үзэлд орохуйн дэлгэрэнгүй номлол тааллыг машинд тодруулагч”, Банчин Содномдагвын “Билиг барамидын магадлан шинжлэл” зэрэг буддын гүн ухааны бусад эх сурвалжийг ашиглан, ном хэлэлцэх, мэтгэлцэх аргаар туурвижээ.

Эрэн хамба Лувсанцэрэнгийн “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул” бүтээл нь лам хуврагуудын буддын гүн ухааны гол ойлголтуудыг ойлгож ухаарах, бясалгах, амьдралдаа хэрэгжүүлэхэд чухал гарын авлага бол, буддын судлаачдын хувьд шашны номлол сургаалын үүсэл хөгжил, тус зохиолын буддын гүн ухааны сургалтад эзлэх байр суурь, эх сурвалжийн харьцуулсан судалгааны чухал эх сурвалж болох ач холбогдолтой юм.

бөгөөд түүнд: 1. Бие лагшиний рид хувилгаан, 2. зарлиг бүгдийг өгүүлэхийн рид хувилгаан, 3. тааллыг хойно үзүүлэхийн рид хувилгаан гэх мэт гурав болно.

30 *Vsat gan bzhi*, Бясалгалын дөрвөн үе шат нь: 1. Шинжлэн судлаж, шалгах аас ангижирсаны дараа үүсэх баяр баясгалан, амгалан нь бясалгалын нэгдүгээр үе болно. 2. Сэтгэлийн дотоодод төрөх их баяр хөөр, амгалан нь бясалгалын хоёрдугаар үе шат болно. 3. Тэгш орших, дурдан санах, мэдлийн тааламжтай байдал нь бясалгалын гуравдугаар үе, 4. Амгалан бус, зовлон бусын тэгш сэрэл болон машинд ариун дурдах сэтгэл нь бясалгалын дөрөвдүгээр үе шат болно.

31 *Gzugs med bzhi*, Дүрс үгүйн дөрвөн орон нь: 1. Огторгуй хязгааргүй. 2. тийн мэдэл хязгааргүй. 3. алин ч үгүйн орон, 4. буй бус, үгүй бус сэлтийн дүрс үгүйн орон болно.

32 *Tshad med bzhi*, Цаглашгүй хамаг амьтаныг бодож бясалгасан буянаас үүсэх сэтгэлийн хэв шинжүүд нь: 1. Асрахуй, 2. энэрэн нигүүлсэхүй, 3. даган баясахуй, 4. тэгш үзэхүйн цаглашгүй

Ном зүй:

1. Э.Ариунаа (Ред), Буддын судлалын хүрээлэн, Буддын онолын шастарууд, Улаанбаатар, 2015
2. Жанжаа хутагт Ролбийдорж, Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг, ШУА, Хэл зохиолын хүрээлэн, УБ, 2021
3. Г.Мягмарсүрэн, Бодь мөрийн зэргийн дээж бичиг, Улаанбаатар, 2021
4. Р.Бямбаа (Ред) Монгол билиг цуврал, Монголчуудын Төвөд хэлт бүтээлийг судлах цуврал, Гавж Лувсанцэрэнгийн зохиолын эмхэтгэл(1873-1934), “Илт номын сангаас эхтэй эргэлзээг тасдагч эрдэнийн тодорхой зул”, УБ, 2013
5. Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, Улаанбаатар, 1997
6. slo dpon sha' kya'i dge slong dbyig gnyen. “chos mngon pa'i mdzod kyi tshig le'ur byas pa” CIHTS, Sarnath, Varanasi (U.P) India, 1995
7. Dung dkar blo bzang 'phrin las, dung dkar tshig mdzod cen mo, krung go'I bod rig pa dpe skrun khang, China, 2002
8. Chandradhar Sharma, A Critical Survey of Indian Philosophy, Motilal Banarsidass, Delhi, India, 1987
9. Carl Olson, Religious Studies, The Key Concepts, Routledge, UK, 2011
10. Ragchaa Byambaa, Marek Mejer , *The Abhidharma Commentaries written by Mongolians in Tibetan*, Rocznik Orientalistyczny. Polska Akademia Nauk Komitet Nauk Orientalistycznych. Tom. LVIII. Warszawa, 2005.

Abstract

In this article, the origin, development, and transformation of the main source scriptures of Abhidharma pitaka, will clarify the theme, structure, content, ideology of “Abhidharmakosha” of the Indian Buddhist master Vasubandhu and its’ the position, features, and significance in the Buddhist philosophy.

“Abhidharmakosha” is a canon that deals with a wide range of topics, such as Buddhist cognition, metaphysics, cosmology, problems of suffering and happiness in human life, ethics, various features of human mind, the path to enlightenment, meditation, and wisdom etc.,

Therefore, “Abhidharmakosha” is an important guide book for the study of Buddhist philosophy in India, Tibet, Mongolia, Buriad, Tuva, Kalmyk, and Inner Mongolia. Mongolians have made commentaries on the “Abhidharmakosha” canon, and one of them is the work of Eren Khambo lama Luvsantsereng (1873-1934) entitled “The clear lamp of the gem that cutting doubts from the Abhidharmakosha”.

Luvsantseren’s work is unique, because it was written in the form of a Buddhist philosophical debate in order to clarify terms and concepts of Buddhist philosophy.